

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ АСУУДЛААР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 12 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
 хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн С.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Л.Эрдэнэчимэг нь Бүгд Найрамдах Болгар Ард Улсын Софи хотын их сургууль, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийг төгссөн. Биологич, эрх зүйч мэргэжилтэй. Биологийн ухааны доктор (Ph.D) зэрэгтэй.

Тэрээр 1990-1992 онд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1992-1994 онд "Монос" Хувиараа эрхлэх аж ахуйн захирал, 1994-2008 онд "Моносфарм трейд" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ерөнхий захирал, 2008-2012 онд "Монос Групп" Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дэд ерөнхийлөгч зэрэг албан тушаалуудыг хашиж байсан бөгөөд 2012 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, мөн оноос Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны даргаар сонгогдон ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны даргаар сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар гарсан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

С.БАТБОЛД